



Өмнөговь аймгийн
Статистикийн хэлтэс



2019 оны жилийн ЭЦСИЙН ЭМХЭТГЭЛ

Эмхэтгэсэн: У.Хоролмаа

Хянасан: С.Бямбабаатар

Даланзадгад

2020 он

АГУУЛГА

Өмнөх үг

Өмнөговь аймгийн тухай

БҮЛЭГ 1. Хүн ам зүйн байдал

БҮЛЭГ 2. Хөдөлмөр эрхлэлт

БҮЛЭГ 3. Нийгмийн үйлчилгээний салбарууд

3.1 Боловсрол, соёл, урлаг

3.2 Эрүүл мэнд

БҮЛЭГ 4. Дотоодын нийт бүтээгдэхүүн

БҮЛЭГ 5. Төсөв, санхүү

БҮЛЭГ 6. Хөдөө аж ахуйн салбар

БҮЛЭГ 7. Үйлдвэрлэл, үйлчилгээний салбарууд

7.1 Аж үйлдвэр

7.2 Барилга

7.3 Тээвэр

7.4 Холбоо

БҮЛЭГ 8. Аж ахуйн нэгж, байгууллагын тоо, бүтэц

Өмнөх үг

Аймгийн Статистикийн хэлтэс нь орон нутгийн хэмжээнд статистик тоон мэдээллийг цуглуулах, боловсруулах, орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн асуудлаар танилцуулга, судалгаа бэлтгэж тархаах үндсэн чиг үүрэгтэй 10 албан хаагчтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Үндсэн 5 албан хаагч, зохион байгуулагч 1, гэрээт 1 ажилтан, өрхийн нийгэм эдийн засгийн болон ажиллах хүчний судалгааны 3 гэрээт судлаач ажиллаж байна. Үндсэн албан хаагчид бүгд статистикч, эдийн засагч, мэдээлэл технологийн чиглэлээр мэргэжил эзэмшсэн ажилтнууд байгаа бөгөөд судлаачид ч мөн статистикч, эдийн засагч болон нийгмийн салбарын мэргэжилтэй хүмүүс байна.



Хэрэглэгч та бүхэнд толилуулж буй Өмнөговь аймгийн нийгэм, эдийн засгийн байдлын энэхүү танилцуулга, холбогдох тоо мэдээллийг аймаг, орон нутгийнхаа хөгжлийн бодлого, хөтөлбөр боловсруулах болон шинжилгээ судалгааны ажилд өргөнөөр ашиглахыг хүсье.

Танилцуулгын болон статистикийн мэдээллийн талаар өөрийн санал хүсэлтээ бидний хаягаар ирүүлбэл талархан хүлээн авч хамтран ажиллах болно.

Хаяг: Өмнөговь аймгийн Нутгийн Удирдлагын ордон, өрөө 304.

Утас: 70533061

70533439

Цахим хаяг: umnugovi@nso.mn

Веб хуудас: <http://www.umnugovi.nso.mn/>

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС


ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ТУХАЙ



Төрийн дээд шагнал “Алтан гадас одонт, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонт Өмнөговь аймаг нь 1931 онд Богд Хан-Уул, Цэцэрлэг Мандлын аймгуудаас таслан Говь Гурвансайхан уулын зүүн урд энгэрт, “Далан булаг” хэмээх газар байгуулагдсан. Эдүгээ 88 жилийн арвин их түүхтэй. МУ-ын өмнөд цэгт байрлах ба хамгийн их нутаг дэвсгэртэй буюу 165 мян хавтгай дөрвөлжин км газар нутагтай. Урд талаараа БНХАУ-ын ӨМӨЗО-ны Алшаа, Баяннуур аймгуудтай хиллэдэг бол хойд хэсгээрээ МУ-ын Баянхонгор, Өвөрхангай, Дундговь, Дорноговь аймгуудтай хил залгаа оршдог. Аймгийн төв Даланзадгад нь нийслэл Улаанбаатар хотоос 570 км зайтай. Засаг захиргааны нэгжийн хувьд 15 сум, 59 багтай.

Байгаль цаг уурын хувьд эрс тэс уур амьсгалтай, өвөлдөө -20-30 градус хүртэл хүйтэрдэг, дулааны улиралд халуун нь 30-38 градус хүрдэг онцлогтой.

Байгалийн үзэсгэлэнт Хонгорын голын элсэн уул, Монголын алдарт 33 говийн нэг Галба, Борзон, Зээмэг, Заг сүүжийн алдарт их говь, 50-120 сая жилийн тэртээ амьдарч байсан эртний үлэг гүрвэлийн чулуужсан яс, өндөг, чулуужсан мод зэрэг палентологийн олдворууд олдсон Баян заг, дэлхийд ховорт тооцогдох Нэмэгт, хэрмэн цав, Шаригийн ганга, Бүгийн цав, зэрэг байгалийн тогтоц бүхий үзэсгэлэнт газрууд олон бий. Ан амьтан араатан жигүүртэн, ховор нандин ургамлаар баялаг сүрлэг сайхан Говь гурван сайхан Ёлын ам, Мухар шивэртийн ам зэрэг нь гадаад дотоодын жуулчдын харааг татаж сэтгэлийг хөдөлгөж Өмнөговьчууд үзэсгэлэнт онгон дагшин байгалиараа дэлхийд гайхагдаж байна. Түүнчлэн Ноён Хутагт Данзанравжаагийн байгуулсан дэлхийн энергийн төв Дэмчогийн хийд, дэлхийд данстай галбын улаан, ханын хэцийн хүрэн тэмээд, хараа цуцаам удам тал, говь хангай хосолсон байгалийн үзэсгэлэн олонтаа билээ.



Манай аймаг нь 69902 хүн амтай. МУ-ын үнэт эрдэнэ хүүхэд залуусын боловсрол мэдлэгт онцгой анхаарч сургууль, цэцэрлэгийг шинээр барьж ашиглалтад оруулж байгаа бөгөөд өнөөдрийн байдлаар манай аймагт Ерөнхий боловсролын 22 сургууль, Сургуулийн өмнөх боловсрол олгох 29 цэцэрлэг ажиллаж байна.

Хүн ардын эрүүл мэндийг дэмжсэн үндэсний болоод орон нутгийн төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах ажлууд шат дараатай хийгдэж байна. Аймгийн хэмжээнд төрийн болон хувийн хэвшлийн 101 эрүүл мэндийн байгууллага ажиллаж байна. Үүнд: Эрүүл мэндийн газар, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Зооноз өвчин судлалын төв, Цогтцэций, Ханбогд, Ноён сумын Сум дундын эмнэлэг, Сумын Эрүүл мэндийн төв 11, Өрхийн Эрүүл мэндийн төв 4, улсын төсвийн эмнэлэг 24, цэргийн ангийн 3 эмнэлэг, хувийн эмнэлэг 25, хувийн эмийн сан 43, эргэлтийн эмийн сан 14, эм ханган нийлүүлэх төв 4 тус тус ажиллаж байна. Эрүүл мэндийн байгууллагуудад нийт 925 эмч, ажиллагсад ажиллаж байгаагийн 208 нь их эмч, 253 нь сувилагч, тусгай мэргэжилтэн ажиллаж орон нутгийн иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж байна.

2019 онд жилийн эцсийн мал тооллогоор нийт мал 3000303 толгой болсон нь өнгөрсөн оны мөн үеэс 401.8 мянган толгойгоор өссөн үзүүлэлттэй байна. Үүнээс дэлхийн улаан номонд багтдаг 2 бөхт тэмээний өлгий нутаг бөгөөд нийт 157863 толгой тэмээн сүрэг тоолуулж, тоогоороо улсдаа төдийгүй дэлхийд тэргүүлэх байр эзэлдэг.

Өмнөговь аймаг ашигт малтмалын 80 гаруй орд, 200 гаруй илрэлтэйгээс Тавантолгой, Оюу толгой, Нарийнсухайт стратегийн ач холбогдолтой 3 томоохон орд газарт тогтоогдож нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд Оюутолгой, Тавантолгой, Эрдэнэс таван толгой, Энержи ресурс, Терра энержи, Жавхлант орд зэрэг 14 компани ашигт малтмалын олборлолтын үйл ажиллагаа явуулж байна.

Аймгийн төсвөөс Улсын төсөвт 2015 онд 10.0 тэрбум төгрөг, 2016 онд 16.7 тэрбум төгрөг, 2017 онд 29.2 тэрбум төгрөг, 2018 онд 66.1 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж, 2019 онд 58.0 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээр Монгол улсын төсвийн тухай хууль болон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлагдсан байна.

ЗАСАГ ЗАХИРГААНЫ НЭГЖ, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, СУМААР

Сумын нэр	Багийн тоо	Нутаг дэвсгэрийн хэмжээ, мян.кв.км	Хүн амын нягтшил /1 км ² -т ногдох хүн/
Дүн	59	165.4	0.41
Баяндалай	3	10.8	0.19
Баян-Овоо	3	10.5	0.17
Булган	4	7.5	0.28
Гурвантэс	5	27.9	0.18
Мандал-Овоо	3	6.4	0.26
Манлай	4	12.4	0.21
Номгон	5	19.5	0.07
Ноён	2	10.6	0.24
Сэврэй	3	8.1	0.25
Ханбогд	5	15.2	0.50
Ханхонгор	4	9.9	0.20
Хүрмэн	3	12.4	0.13
Цогт-Овоо	3	6.5	0.28
Цогтцэций	4	7.2	1.09
Даланзадгад	8	0.5	52.29

Бүлэг 1



1. Хүн амын тоо, түүний өсөлт, өөрчлөлт

Өмнөговь аймаг 2019 оны эцэст 69902 хүн амтай болж 2018 оны эцсийн хүн амын мэдээнээс 2.6 хувиар буюу 1788 хүнээр өслөө. Нийт хүн амын 51.1 хувь буюу 35720 эрэгтэйчүүд, 48.9 хувь буюу 34182 эмэгтэйчүүд эзлэж байна. Насны бүтцээр ангилвал 31.8 хувийг 0-14 насны хүүхэд, 62.0 хувийг 15-59 насны, 6.2 хувийг 60-с дээш насны хүн ам эзэлж байна.

Хүснэгт 1.1 Өмнөговь аймгийн өрх, хүн амын тоо


Сум	2015		2016		2017		2018		2019	
	Өрх	Хүн ам	Өрх	Хүн ам	Өрх	Хүн ам	Өрх	Хүн ам	Өрх	Хүн ам
Даланзадгад	7649	23298	8023	24072	8365	24863	8759	26143	8191	26386
Баяндалай	685	2090	695	2098	684	2082	690	2088	652	2089
Баяновоо	591	1716	606	1758	612	1733	613	1753	583	1868
Булган	692	2092	701	2066	727	2122	726	2104	716	2050
Гурвантэс	1444	4617	1487	4729	1527	4869	1558	4934	1571	5129
МандалОвоо	529	1615	527	1628	531	1602	541	1633	516	1613
Манлай	710	2481	725	2499	741	2577	746	2588	719	2633
Ноён	436	1336	442	1357	446	1394	447	1406	451	1398
Номгон	829	2557	829	2567	845	2580	840	2564	782	2518
Сэврэй	621	2026	632	2055	621	2009	631	2008	630	2029
Ханбогд	1668	5344	1768	6387	1834	6978	1988	7668	1954	8718
Ханхонгор	714	2047	725	1992	757	2010	759	1987	790	1986
Хүрмэн	535	1597	551	1590	559	1593	548	1553	542	1556
Цогт-Овоо	539	1694	577	1760	588	1811	587	1816	557	1818
Цогтцэций	2352	7030	2381	7103	2441	7422	2550	7869	2443	8111
Дүн	19994	61540	20669	63661	21278	65645	21983	68114	21097	69902

Эх сурвалж: Албан ёсны статистикийн мэдээ

Хүн амын нас, хүйсийн суварга

Нас хүйсийн суварга нь хүн амыг нас, нас хүйсээр хуваарилан харуулдаг босоо байрлалтай диаграмм юм. Онолын хувьд босоо тэнхлэгт нийт хүн амд тухайн насны хүн амын эзлэх хувийн жингээр харуулах ба бага насныхныг суваргын доод хэсэгт, хэвтээ тэнхлэгийн зүүн талд эрэгтэйчүүдийг, баруун талд эмэгтэйчүүдийг тус тус дүрслэн харуулдаг. Хүн амын нас, хүйсийн пирамид нь цаг хугацааны тодорхой үеийн хүн амын нөхөн үржихүйн тасралтгүй процессын явцыг харуулна. Хэрэв хүн амын нөхөн үржихүйн процессын тухайлбал төрөлт, нас баралтын түвшинд ямар нэг нөлөө гараагүй тохиолдолд насны пирамид нь тэнцүүхэн дүрслэгдэх ба урт хугацааны туршид төрөлтийн өндөр түвшин хадгалагдаж, нас баралтын түвшин ч харьцангуй өндөр байсан тохиолдолд пирамидын суурь нь өргөн, орой руугаа нарийссан хэлбэртэй, харин төрөлт, нас баралтын түвшин бага байсан тохиолдолд пирамидын суурь нь нарийхан, орой руугаа өргөссөн хэлбэртэй байдаг.

Зураг.1.1 2019 оны хүн амын тоо, насны бүтцээр ангилвал



Хүснэгт 1.2 Хүн амын тоо, суурьшлын байдлаар, 2015-2019 он

Он	Аймгийн төв		Сумын төв		Хөдөө	
	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй
2015	22602	11812	20055	9908	18883	8798
2016	24861	13015	21207	10555	17593	8131
2017	25016	13119	22623	11071	17936	8438
2018	26143	13694	18109	8764	23862	11420
2019	26386	13824	15671	7611	27845	12747

Эх сурвалж: Албан ёсны статистикийн мэдээ

2019 онд аймгийн төвийн хүн ам суурь оноос 40.7 хувиар, өмнөх оноос 0.9 хувиар өсч, сумын төвийн хүн ам өмнөх оноос 13.5 хувиар буурсан байна. Хөдөөгийн хүн амын тоо 2015 оноос 47.4 хувиар өмнөх оноос 16.6 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Хүн амын хүйсийн байдал

Хүн амын бүтцэд хүн амын нас, хүйсийн байдал чухал байр суурь эзэлдэг бөгөөд эдгээр үзүүлэлтүүдийн өөрчлөлт, түүний шалтгаан зэрэг нь тухайн улс орон, бүс нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн байдалтай уялдсан байдаг.

Хүснэгт 1.3 Хүн амын тоо, хүйсээр 2015-2019 он

Он	Хүн амын тоо			Дүнд эзлэх хувийн жин		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
2015	61540	31020	30520	100.0	50.4	49.65
2016	63661	31960	31701	100.0	50.2	49.8
2017	65645	32986	32659	100.0	50.2	49.8
2018	68114	34232	33882	100.0	50.3	49.7
2019	69902	35720	34182	100.0	51.1	48.9

2019 оны байдлаар аймгийн хүн амын 51.1 хувийг эрэгтэйчүүд, 48.9 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Хүн амын 35720 нь эрэгтэй байгаа нь 2015 оноос 15.1 хувиар, өмнөх оноос 4.3 хувиар өсч, Үүнээс эмэгтэй нь 34182 болж, 2015 оноос 11.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1.4 Төрсөн хүүхдийн тоо, хүйсээр, оны эцэст

Он	Бүгд	Үүнээс:		Улсын дүнд эзлэх хувь	1000 хүнд ногдох төрөлт
		Эрэгтэй	Эмэгтэй		
2015	1668	861	867	2.06	27.5
2016	1613	808	805	2.02	25.7
2017	1473	768	705	2.01	26.3
2018	1858	932	924	2.36	27.2
2019	1923	1018	905	2.41	24.2

Эх сурвалж: Албан ёсны статистикийн мэдээ

Төрсөн хүүхдийн тоо 2019 онд 1923 байгаа нь 2015 оноос 15.2 хувиар өмнөх оноос 3.5 хувиар өссөн байна.

Аймгийн хүн амын 1000 хүнд ногдох төрөлт 2019 онд 24 болж 2009 оноос 3 төрөлтөөр буурч, 2010 оноос 2 төрөлтөөр өсч, 2018 оноос 3 төрөлтөөр буурсан байна. Харин 2013 оноос 7 төрөлтөөр буурсан харагдаж байна.

Хүн амын өсөлт, өөрчлөлтийг шууд тодорхойлдог төрөлт, нас баралт, шилжих хөдөлгөөн гэсэн 3 үндсэн үзүүлэлтээс төрөлт нь хүн амын өсөлтөд эерэг нөлөө үзүүлдэг гол хүчин зүйл мөн. Төрөлт нь зөвхөн хүн амын тоо хэмжээнд нөлөөлөөд зогсохгүй нас, хүйсийн бүтцэд ч нөлөөлдөг.

Хүснэгт 1.5 Хүн амын ердийн цэвэр өсөлт, бууралт, оноор

Он	Төрөлт	Нас баралт	Ердийн цэвэр өсөлт
2015	1668	366	1302
2016	1613	346	1267
2017	1473	354	1119
2018	1858	370	1488
2019	1923	395	1528

Эх сурвалж: Албан ёсны статистикийн мэдээ

ӨРХИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Манай улсын нийт өрх гэрийн тоо 1960-1980-аад онд 26.9 хувь өссөн нь өрхийн өсөлтийн оргил үе байсан байна. Энэ нь тухайн үеийн нам, засгаас гэрлэлтийг болон олон хүүхэд төрүүлэхийг дэмжих бодлого явагдаж, тэдгээрийг урамшуулах олон төрлийн арга хэмжээ авч байсантай холбоотой юм. 1990 оноос гэрлэлт цөөрч, өрхийн өсөлт буурч эхэлсэн байна.

Өрхийн тоо 2019 онд 21097 болж 2011 оноос 23.6 хувиар, 2015 оноос 5.5 хувиар өсөж, 2018 оноос 4.1 хувиар буурсан байна. Өрхийн тооны өсөлт бууралт нь өрхийн гишүүдийн тоотой салшгүй холбоотой байдаг.

Өмнөговь аймгийн хувьд 1 өрхөд ногдох өрхийн гишүүдийн тоог онуудаар авч үзвэл:

2015 онд – 3.0
2016 онд – 3.1
2017 онд – 3.1
2018 онд – 3.1
2019 онд – 3.1



Өмнөговь аймаг 2019 оны эцэст өрхийн тоо 21097 болж өмнөх оноос 886 өрхөөр буюу 4.1 хувиар буурсан дүнтэй байна.



Бүтэн, хагас өнчин хүүхдийн мэдээлэл

“Бүтэн өнчин хүүхэд” гэж эцэг, эх нь тогтоогдоогүй, эсвэл эцэг эх нь хоёулаа нас барсан, сургаггүй болсон, эрх зүйн чадамжгүй, эцэг, эх байх эрхээ шүүхийн шийдвэрээр хязгаарлуулсан, хасуулсан бол тухайн шийдвэр хүчин төгөлдөр байх хугацаанд, түүнчлэн эцэг тодорхойгүйн улмаас эхтэйгээ амьдарч байгаад эх нь нас барсан, гэр бүл салсны улмаас асрамждаа авсан эх /эцэг/ нь нас барсан 18 хүртэлх насны хүүхдийг хамруулна./ Монгол улсын Нийгмийн халамжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.7/

Хүснэгт 1.6 Бүтэн, хагас өнчин хүүхдийн тоо, сумдаар

Сумын нэр	Бүтэн өнчин хүүхдийн тоо			Хагас өнчин хүүхдийн тоо		
	2017	2018	2019	2017	2018	2019
Баяндалай	1	1	1	18	28	23
Баян-Овоо	3	3	3	15	14	14
Булган	2	1		32	12	10
Гурвантэс				57	56	73
Мандал-Овоо	2	1	1	15	23	15
Манлай	2	2	2	28	25	25
Номгон	1	1		20	17	14
Ноён		1	1	8	5	7
Сэврэй	2	2		28	13	18
Ханбогд	3	6	6	38	29	31
Ханхонгор	1	1	1	35	25	16
Хүрмэн	1	1	1	16	11	17
Цогт-Овоо		1		29	23	18
Цогтцэций	5	2	6	62	62	75
Даланзадгад	9	7	11	138	134	210
Дүн	32	30	33	539	477	566

Эх сурвалж: Албан ёсны статистикийн мэдээ

2019 оны жилийн эцсийн байдлаар өрх, хүн амын зарим үзүүлэлтийн мэдээгээр аймгийн хэмжээнд бүтэн өнчин хүүхэд 33 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 10.0 хувиар, хагас өнчин хүүхэд 566 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 18.6 хувиар тус тус өссөн байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд

Бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согогийн улмаас бусдын ажил нийгмийн харилцаанд оролцох чадвар нь бүрэн болон 12 сараас дээш хугацаагаар хязгаарлагдсан хүнийг хөгжлийн бэрхшээлтэй гэнэ. /Хөдөлмөр магадлах комиссоор хөгжлийн бэрхшээлтэй гэж тодорхойлогдсон хүнийг хамруулна./

Аймгийн хэмжээнд 2019 оны жилийн эцсийн байдлаар хөгжлийн бэрхшээлтэй хүн 2107 байгаагийн 44.9 хувь буюу 947 нь эмэгтэй байна. Хөгжлийн бэрхшээлтэй нийт иргэдийн 10.8 хувь буюу 229 хүн хөдөлмөр эрхэлж байна. Мөн өрх толгойлсон хүний тоо 2397 байгаа нь өмнөх оны мөн үеэс 8.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна.


Хүснэгт 1.7 Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, оноор

Он	2015	2016	2017	2018	2019
Бүгд	1604	1853	1985	1985	2107
бүгдээс эмэгтэй	712	834	895	899	947
бүгдээс төрөлхийн	591	856	995	1024	1016

Эх сурвалж: Албан ёсны статистикийн мэдээ

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд 2019 онд 2107 болж 2015 оноос 31,3 хувиар, 2018 оноос 6.1 хувиар тус тус өссөн байна. Үүнээс төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо 2018 оноос 8 буюу 0.8 хувиар буурсан байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 2007 онд 46.5 хувь нь, 2015 онд 44.4 хувь нь, 2016 онд 45 хувь нь, 2019 онд 44.9 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.

Зураг 1.3 Хөгжлийн бэрхшээлтэй иргэд / 2015-2019 он /



Бүлэг 2




Хүснэгт -2.1 Өмнөговь аймгийн хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний үзүүлэлт

	2015	2016	2017	2018	2019
Хөдөлмөрийн насны хүн ам	39555	40675	41691	42706	43359
Эдийн засгийн идэвхтэй хүн ам	29046	28370	30294	32021	32474
Үүнээс: ажиллагчид	25613	24314	25324	29680	30517
Ажилгүй иргэд	3433	4056	4970	2340	1957
Ажиллах хүчний оролцооны түвшин	69.7	69	68.8	69.0	71.0
Ажил эрхлэлтийн түвшин	61.5	59.1	57.5	64	66.7
Ажилгүйдлийн түвшин	11.8	14.3	16.4	7.3	6.0


Эх сурвалж: АХС-ны үр дүнгээс

Зураг-2.1 Өмнөговь аймгийн хөдөлмөрийн насны хүн ам, оны эцсээр



Энэхүү зургаас харахад Өмнөговь аймгийн хүн амын хөдөлмөрийн насны хүн ам 2015-2019 он хүртэл тасралтгүй өссөн үзүүлэлттэй харагдаж байна. 2019 оныг өмнөх онуудтай харьцуулахад 2016 оныхоос 6.5 хувиар, 2017 оныхоос 4.0 хувиар, 2018 оныхоос 1.5 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Зураг-2.2 2019 оны хөдөлмөрийн насны хүн ам, хүйсээр



Хүснэгт-2.2 Эдийн засгийн идэвхтэй хүн ам, бүсээр, оны эцсээр

Аймаг	2015	2016	2017	2018	2019
	/ мян.хүн /				
Төвийн бүс	208.2	215.2	234.4	234.1	218.0
Говьсүмбэр	6.3	6.2	7.7	7.5	8.0
Дархан-Уул	39.8	38	42.5	39.2	42.8
Дорноговь	27.1	31.2	33.4	31.3	33.0
Дундговь	21.2	22.2	23.6	24.5	23.2
Өмнөговь	29.1	28.4	30.3	32.0	32.5
Сэлэнгэ	37.4	40.2	46.5	48.6	37.7
Төв	47.3	49	50.3	51.0	40.8

Эх сурвалж: АХС-ны үр дүнгээс

Төвийн бүсийн эдийн засгийн идэвхтэй хүн ам 2019 онд 218.0 мянган хүн байгаа нь 2018 оныхоос 16.1 мянган хүнээр буюу 6.8 хувиар буурсан байна. Өмнөговь аймгийн хувьд эдийн засгийн идэвхтэй 32.5 мянга хүн ам байгаа нь өмнөх онтой харьцуулахад 0.5 мянган хүнээр буюу 1.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Тус аймгийн эдийн засгийн идэвхтэй хүн амын тоог 2016, 2017, 2018 оныхтой харьцуулахад өссөн үзүүлэлтийг дээрх (хүснэгт 6)-аас харж болох юм.

Хүснэгт-2.3 Ажилгүйдлийн түвшин, улс, бүсээр


Бүс	2015	2016	2017	2018	2019
Улсын дүн	7.5	10.0	8.8	7.8	10.0
Баруун бүс	9.2	12.1	10.7	8.9	11.7
Хангайн бүс	4.9	10.6	9.8	7.1	8.2
Төвийн бүс	8.9	9.2	8.3	7.6	7.6
Зүүн бүс	10.7	11.4	10.4	8.7	11.9
Улаанбаатар	6.9	9.1	7.5	7.6	11.0

Эх сурвалж: АХС-ны үр дүнгээс

Ажилгүйдлийн түвшин улсын хэмжээнд 10.0 хувь байгаа нь өмнөх мөн үеийнхтэй харьцуулахад 2.2 пунктээр дээгүүр байна. Харин 2015 оныхоос 2.5 пункт, 2017 оныхоос 1.2 пунктээр тус тус дээгүүр үзүүлэлттэй байна.

Бүсийн түвшинд авч үзвэл зүүн бүсийн хувьд ажилгүйдлийн түвшин 11.9 хувь байгаа нь бусад бүсийг бодвол өндөр үзүүлэлттэй байна.

Бүлэг 3



3.1. БОЛОВСРОЛ, СОЁЛ, УРЛАГ


Аймгийн хэмжээгээр 2019-2020 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын төрийн хэвшлийн 22 сургууль үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 476 бүлэгт өдрийн ангийн 13413 сурагчид хамрагдан суралцаж байна. Энэ хичээлийн жилд аймгийн хэмжээнд 20 дотуур байранд 958 хүүхэд амьдарч байгаагийн 56.2 хувийг эмэгтэй сурагчид эзэлж байна. Төрийн хэвшлийн ерөнхий боловсролын сургуульд 692 багш ажиллаж байна.

ЗУРАГ 3.1 БОЛОВСРОЛЫН ҮЗҮҮЛЭЛТ

Үзүүлэлт	2015/2016	2016/2017	2017/2018	2018/2019	2019/2020
ЕБСургуулийн тоо	20	20	21	22	22
ЕБС-д өдрийн ангид суралцагчдын тоо (1000 хүн)	11.0	11.4	11.8	12.1	13.4
ЕБС-ийн хамран сургалтын бохир жин (1-9 р анги)	92.2	97.6	96.9	82.9	89.6
ЕБС-ийн суралцагч-багшийн харьцаа	18.4	18.8	18.9	19.1	19.4
СӨБ-ийн байгууллагын тоо	27	27	28	29	29
СӨБ-д хамрагдсан хүүхдийн тоо (1000 хүүхэд)	4.7	5.2	5.5	5.4	5.7
СӨБ-д ажиллаж байгаа нэг багшид ногдох хүүхэд	30.6	31.6	32.2	32.2	30.3

Сургуулийн өмнөх боловсрол олгох 29 төрийн өмчийн цэцэрлэгийн нийт 188 бүлэгт 5711 хүүхэд хүмүүжиж байна. Энэ хичээлийн жилд СӨБ-д 413 ажиллагчид ажиллаж байгаагийн 91 хувь нь буюу 376 үндсэн багш ажиллаж байна.

ЗУРАГ.3.2 Өмнөговь аймгийн сургууль, цэцэрлэгийн тоо, оноор



Эх сурвалж: аймгийн БСУГ-ын статистикийн мэдээ

СОЁЛ. УРЛАГ

Аймгийн хэмжээнд Соёлын төвийн дэргэд үндэсний хөгжим, бүжиг, дуу, драм, амьд хөгжим, найрал дуу, соёлын өв, номын сангийн идэвхитэн уншигчдын клуб, хүүхдийн цирк, уран зураг, төгөлдөр хуур, уран нугаралт зэрэг 6 төрлийн дугуйлан хичээллүүлж, хүүхэд багачууд болон ардын авьяастныг хөгжүүлж байна.

Өмнөговь аймгийн хэмжээнд түүх соёлын үл хөдлөх 213 дурсгалт газрын 2348 дурсгалыг улсын бүртгэл мэдээллийн санд бүртгүүлж, түүх соёлын үл хөдлөх дурсгалт 33 газрын хамгаалалтын бүсийг шинэчлэн тогтоосон.

Мэргэжлийн урлагийн байгууллагын тоглолт 2019 онд 3711 болж, 2015-2018 онуудынхаас тогтмол буурсан үзүүлэлттэй байна. / Хүснэгт 3.2.1/

ХҮСНЭГТ 3.2.1 СОЁЛ УРЛАГИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТҮҮД. 2015-2019 ОН

Он	Мэргэжлийн урлагийн байгууллагын тоглолт тоо			Музейн үзэгчдийн тоо. мян. хүн			Номын сангийн тоо		
	Улсын дүн	Төвийн бүс	Өмнөговь аймаг	Улсын дүн	Төвийн бүс	Өмнөговь аймаг	Улсын дүн	Төвийн бүс	Өмнөговь аймаг
2015	4442	791	30	583.4	80.2	14.9	370	101	15
2016	5204	861	73	534.7	87.3	19.4	362	101	14
2017	4740	33	76	577.4	103.2	19.3	362	101	14
2018	4094	903	50	781.4	145.5	47.9	364	102	15
2019	3711	617	73	742.9	77.2	11.3	364	101	14

Эх сурвалж: Албан ёсны статистикийн мэдээ

Музейн үзэгчдийн тоо улсын хэмжээнд 2019 онд 742.9 мянга болж, 2018 оныхоос 4.8 хувиар буурч, харин 2015-2017 онуудынхаас 27.3-38.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Өмнөговь аймагт музейн үзэгчдийн тоо 2019 онд 11.3 мянга болж, 2015-2018 оныхоос буурчээ.

Номын сангийн тоо улсын хэмжээнд 2019 онд 364 болсон нь өмнөх оныхоос өөрчлөлтгүй байна.

3.2 ЭРҮҮЛ МЭНД



Аймгийн хэмжээгээр эрүүл мэндийн байгууллага 101 ажиллаж байгаагаас улсын төсвийн эмнэлэг 24, өрхийн эмнэлэг 4, цэргийн ангийн 3 эмнэлэг, хувийн эмнэлэг 25, хувийн эмийн сан 43, эргэлтийн эмийн сан 14, эм ханган нийлүүлэх төв 4 тус тус ажиллаж байна.

Хүснэгт 3.2.1 Өмнөговь аймгийн Эрүүл мэндийн байгууллагын зарим үзүүлэлт, оноор

Үзүүлэлт	2000	2005	2010	2015	2019
Их эмч	88	79	117	170	208
Эм зүйч	10	8	15	25	45
Ердийн өсөлт (хүн)	744	482	822	1 130	1 131
Нэг эмчид ногдох хүн	517	606	440	356	336
Нэг сувилагчид ногдох хүн	395	386	419	346	381
1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдлийн түвшин	45.8	29.0	22.4	16.6	21.2
Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлт тутамд)	55.6	35.5	26.7	19.9	25
Үр хөндөлт	485	427	119	513	713
Халдварт өвчнөөр өвчлөгчид	387	160	287	989	739

Эх сурвалж: Аймгийн ЭМГ-ын статистикийн мэдээ

2019 оны эхний 12 сарын байдлаар аймгийн хэмжээгээр 1638 эх амаржиж, 347 хүн нас барсан нь урьд оны мөн үеэс төрөлт 6.6 хувиар, нас баралт 7.4 хувиар тус тус нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 3.2.1 Өмнөговь аймгийн Эрүүл мэндийн зарим үзүүлэлт, оноор

Үзүүлэлт	2017.XII	2018.XII	2019.XII	2019/2018
Амаржсан эхийн тоо	1297	1538	1638	106.5
Амьд төрсөн хүүхдийн тоо	1301	1553	1646	106.0
Төрөхийн улмаас эндсэн эхийн тоо	1	0	0	0.0
0-1 хүртэл насны хүүхдийн эндэгдэл	21	26	35	134.6
1-5 хүртэл насны хүүхдийн эндэгдэл	5	4	6	150.0

ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН

Бүлэг 4



ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН


Урьдчилсан гүйцэтгэлээр 2019 онд Өмнөговь аймаг Монгол улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 2.3 хувь, төвийн бүсийн 20.5 хувь болох 728.5 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаагийн дээр нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн 10.5 сая төгрөг болж улсын хэмжээнд Орхон аймаг, Улаанбаатар хот, Дорнод аймгийн дараа 4-т эрэмбэлэгдэж байна.

ХҮСНЭГТ 4.1 ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН, бүс, аймаг, нийслэлээр, оны үнээр* 2016-2019 он

	2016			2017**				
	ДНБ, сая төг	Дүнд эзлэх хувь			ДНБ, сая төг	Дүнд эзлэх хувь		
		Хөдөө аж ахуй	Аж үйлдвэр, барилга	Үйлчилгээ		Хөдөө аж ахуй	Аж үйлдвэр, барилга	Үйлчилгээ
Дүн	23 942 866.4	11.5	36.6	51.8	27 876 297.2	10.1	41.4	48.5
Төвийн бүс	2 439 043.8	29.7	35.2	35.2	2 870 828.4	25.0	41.9	33.2
Говьсүмбэр	83 354.9	20.0	38.3	41.7	83 959.4	20.8	38.0	41.2
Дархан-Уул	387 260.4	9.7	42.1	48.2	409 544.4	8.2	46.3	45.6
Дорноговь	272 288.4	25.6	18.1	56.4	296 014.8	27.3	17.4	55.3
Дундговь	226 072.5	55.1	14.1	30.7	258 177.0	56.7	14.7	28.6
Өмнөговь	404 035.8	22.5	42.9	34.7	714 470.2	14.7	57.5	27.8
Сэлэнгэ	555 423.0	23.9	48.1	28.0	598 216.1	20.9	51.2	27.9
Төв	510 608.8	49.4	27.6	23.0	510 446.5	40.9	34.0	25.0
	2018			2019**				
	ДНБ, сая төг	Дүнд эзлэх хувь			ДНБ, сая төг	Дүнд эзлэх хувь		
		Хөдөө аж ахуй	Аж үйлдвэр барилга	Үйлчилгээ		Хөдөө аж ахуй	Аж үйлдвэр барилга	Үйлчилгээ
Дүн	32 411 224.1	10.1	41.4	48.5	32 093 615.4	10.7	42.2	47.1
Төвийн бүс	3 155 898.1	31.7	34.9	33.4	3 552 301.1	31.7	34.9	33.4
Говьсүмбэр	89 146.0	20.8	38.0	41.2	97 640.2	22.6	34.2	43.2
Дархан-Уул	428 447.5	8.2	46.3	45.6	474 710.7	9.2	44.1	46.7
Дорноговь	368 335.5	27.3	17.4	55.3	405 359.7	31.3	20.6	48.1
Дундговь	328 291.5	56.7	14.7	28.7	380 983.3	60.2	16.4	23.4
Өмнөговь	657 803.3	14.7	57.5	27.8	728 463.3	19.8	48.1	32.1
Сэлэнгэ	689 576.9	20.9	51.2	27.9	776 341.0	25.7	48.0	26.4
Төв	594 297.4	40.9	34.0	25.0	688 802.9	47.6	29.9	22.5

Өмнөговь аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүн 2015-2017 онуудад огцом өсөлттэй байгаа нь дараах графикаас тодорхой харагдаж байна. / ЗУРАГ 4.1/

ЗУРАГ 4.1 ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ДНБ, оноор, сая.төгрөгөөр




Дотоодын нийт бүтээгдэхүүнийг салбараар нь авч үзвэл:

Хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуйн салбар 19.8 хувь,

Аж үйлдвэр, барилгын салбар нь 48.1 хувь,

Үйлчилгээний салбар 32.1 хувийг тус тус эзэлж байна. /Зураг 4.2/

ЗУРАГ 4.2 ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ДНБ-НИЙ БҮТЭЦ




Дээрх зургаас харахад хөдөө аж ахуй, үйлчилгээний салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь өмнөх оныхоос өссөн байхад, аж үйлдвэр, барилгын салбарын эзлэх хувь 9.4 пунктээр буурсан үзүүлэлттэй байна.

Өмнөговь аймгийн нэг хүнд ногдох Дотоодын нийт бүтээгдэхүүн нь 2015 онд 4.6 сая, 2016 онд 6.4 сая, 2017 онд 11.0 сая, 2018 онд 9.7 сая, 2019 оны урьдчилсан гүйцэтгэлээр 10.5 сая төгрөгт хүрсэн байна.

Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн нь 2015-2017 онуудад өсөлттэй, харин 2018 онд 1.3 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байсан ч 2019 онд эргээд өсөлт (0.8 пункт) харагдаж байна./Зураг 4.3/

ЗУРАГ 4.3 НЭГ ХҮНД НОГДОХ ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН,
оноор, сая төгрөгөөр



Эх сурвалж: Албан ёсны статистикийн мэдээ

ТӨСӨВ, САХҮҮ

Бүлэг 5



5.1 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО



2020 оны төсвийн жилд улсын төсвийн орлогод 52.1 тэрбум төгрөг, аймгийн төсвийн орлогод 144.5 тэрбум төгрөг, сумын төсвийн орлогод 14.3 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр батлагдаж, гүйцэтгэлийг ханган ажилласан байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2015 онд 27.7 тэрбум төгрөг, 2016 онд 47.2 тэрбум төгрөг, 2017 онд 37.2 тэрбум төгрөг, 2018 онд 48.4 тэрбум төгрөг, 2019 онд 77.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлийн санхүүжилтийг олгосон бөгөөд 2020 онд 99.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлагдаж, гүйцэтгэлийг ханган ажиллаж байна.

5.1.1 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, оны үнээр мян.төгрөг

Үзүүлэлт	2015	2016	2017	2018	2019
Нийт орлого	62 892 780.6	64 822 838.7	114 971 315.0	163 718 636.5	135,630,421.20
Урсгал орлого	62 741 398.7	64 764 383.7	114 877 713.6	163 552 269.3	135,383,219.70
Татварын орлого	59 986 805.4	61 241 020.8	86 936 565.3	91 602 703.7	104,212,891.10
орлогын албан татвар	24 880 004.7	24 717 799.9	35 414 264.3	42 027 907.5	72,316,966.20
-аж ахуй нэгжийн	932 140.5	803 600.7	1 891 818.8	3 374 877.1	3,295,153.30
-хүн амын	23 947 864.2	23 914 199.2	33 522 445.5	38 653 030.4	47,998,284.50
Өмчийн татвар	12 683 668.1	13 369 191.7	25 065 724.1	23 083 712.1	21,023,528.40
Бараа үйлчилгээний татвар	22 423 132.6	23 154 029.2	26 456 576.9	26 491 084.1	31,895,924.90
Автомашин татвар	1 727 722.6	2 684 543.3	2 818 687.5	3 472 937.9	4,204,061.60
Бусад татвар төлбөр хураамж	20 695 410.0	20 469 485.9	23 637 889.4	23 018 146.2	27,691,863.30
Татварын бус орлого	2 754 593.3	3 523 362.9	27 941 148.3	71 949 565.6	31,170,328.60
Хөрөнгийн орлого	151 381.9	58 455.0	93 601.4	166 367.2	247,201.50

Эх сурвалж: Аймгийн СТСХ-ийн мэдээ

5.1.2 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА, эдийн засгийн үйл ажиллагааны чиглэлээр, оны үнээр

Эдийн засгийн үйл ажиллагаагаар	2015	2016	2017	2018	2019
Нийт зардал	35 904.9	56 340.8	2 063 251.7	102 884 259.1	194,248,309.40
Боловсрол үйл ажиллагаа	16 147.0	30 051.1	1 319 639.5	89 234 172.9	26863184.3
Эрүүл мэндийн үйл ажиллагаа	10 110.7	12 802.2	615 043.6	2 227 838.7	4,162,718.60
Нийгмийн даатгал, нийгмийн халамжийн үйл ажиллагаа	8 965.7	12 000.7	0	133 541.0	324901.1
Барилга, хот байгуулалт			24 959.4	6 386 850.4	414967.6
Эдийн засгийн бусад	681.5	1 486.8	103 609.2	4 901 856.1	162482537.8


Эх сурвалж: Аймгийн СТСХ-ийн мэдээ

5.2 БАНК, САНХҮҮ



Мөнгөн хадгаламжийн үлдэгдэл 2019 онд 173.2 тэрбум төгрөгт хүрсэн байна. Сүүлийн 5 жилийн эцсийн байдлаар үзэхэд иргэдийн мөнгөн хадгаламж тогтмол өссөн бөгөөд 2019 оныг өмнөх онуудтай харьцуулбал 2018 оноос 13.8 хувиар, 2017 оноос 41.9 хувиар, 2016 оноос 88.5 хувиар, 2015 оноос 2.0 дахин тус тус өссөн үзүүлэлттэй байна. /Хүснэгт 5.2.1/

5.2.1 ИРГЭДИЙН ХАДГАЛАМЖ, аймаг, жилийн эцсийн байдлаар / тэрбум төгрөг/



Эх сурвалж: Аймагийн Монгол банкны мэдээ

Аймаг дахь банкны салбарын нийт зээлийн үлдэгдэл 286.6 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 10.1 тэрбум төгрөгөөр буюу 3.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 5.2.2 ЗЭЭЛИЙН ӨРИЙН ҮЛДЭГДЭЛ, аймаг, жилийн эцсийн байдлаар



Эх сурвалж: Аймагийн Монгол банкны мэдээ

ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАР

Бүлэг 6



6. ХӨДӨӨ АЖ АХУЙ

2019 оны жилийн эцсийн мал тооллогоор аймгийн хэмжээгээр 7707 малтай өрх, үүнээс 6108 малчин өрх мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлж байна. Аймгийн хэмжээний нийт өрхийн 36.5 хувийг малтай өрх эзэлж байна.

2019 онд мал аж ахуйн салбарт 9671 малчид ажиллаж байна. Нийт малчдын 43.8 хувь нь буюу 4237 эмэгтэйчүүд байна.

ХҮСНЭГТ 6.1 Өмнөговь аймгийн малчин өрх, малчдын тоо, насны бүтэц, оноор

Төрөл	2015	2016	2017	2018	2019
Малтай өрх	6 963	7 172	7 418	7 496	7707
Малчин өрх	5 417	5 647	5 819	5 951	6108
Малчдын тоо	9 588	9 846	9 594	9 593	9671
Үүнээс: 15-34 насны	3 473	3 408	3 084	3 012	2898
35-аас тэтгэвэрт гарах хүртэл насны	5 135	5 353	5 079	5 151	5290
Тэтгэврийн насны	980	1 085	1 431	1 430	1483
Нийт малчдаас эмэгтэй	4 378	4 503	4 315	4 269	4237
Нэг малчин өрхөд ногдох малын тоо /толгойгоор/	379	409	456	436	491

2019 оны мал тооллогын дүнгээр нийт малчин өрхийн 83.7 хувь буюу 5115 өрх цахилгааны эх үүсвэртэй, 77.8 хувь буюу 4754 өрх телевизортой, 57.6 хувь буюу 3521 өрх автомашинтай, 56.4 хувь буюу 3442 өрх мотоциклтой, 0.5 хувь буюу 28 өрх трактортой байна.

Хүснэгт 6.2 Малчдын соёл ахуйн үзүүлэлт

	Өрхийн тоо					Малчин өрхийн тоонд эзлэх хувь				
	2015	2016	2017	2018	2019	2015	2016	2017	2018	2019
Цахилгааны эх үүсвэртэй	4654	4614	4559	4599	5115	85.9	82.4	78.3	77.3	83.7
Телевизортой	4267	4126	4318	4392	4754	78.8	75.6	74.2	73.8	77.8
Автомашинтай	2581	2449	2788	3078	3521	47.6	45.7	47.9	51.7	57.6
Мотоциклтой	2624	2638	2892	2898	3442	48.4	46.5	49.7	48.7	56.4
Трактортой	23	24	14	8	28	0.4	0.4	0.2	0.1	0.5

Эх сурвалж: 2015-2019 оны жилийн эцсийн мал тооллогын дүн

2019 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр Өмнөговь аймгийн 15 сумын 59 багт 3.0 сая толгой мал тоолуулж, 2018 оныхоос 401.8 мянган толгой малаар буюу 15.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 6.3 Өмнөговь аймгийн малын тоо, оны эцсээр

Сумын нэр	2015	2016	2017	2018	2019	2019/2018
Баяндалай	168829	180270	190396	175787	206404	117.4
Баян-Овоо	107805	124227	147595	142224	169701	119.3
Булган	142671	165837	194503	205265	236711	115.3
Гурвантэс	166228	181562	205078	187458	225294	120.2
Мандал-Овоо	135139	157716	185166	209916	234072	111.5
Манлай	133820	160576	188781	205418	220673	107.4
Номгон	244795	262296	289869	262292	302862	115.5
Ноён	116669	119638	126694	108306	132705	122.5
Сэврэй	147538	156286	177238	172662	190480	110.3
Ханбогд	133013	151446	172774	165527	190028	114.8
Ханхонгор	174303	204635	242353	236686	280532	118.5
Хүрмэн	137961	145908	159572	142790	169889	119.0
Цогт-Овоо	85766	105999	131945	140197	154385	110.1
Цогтцэций	82429	102660	130758	135026	159455	118.1
Даланзадгад	78799	94907	111666	108886	127112	116.7
Дүн	2055765	2313963	2654388	2598440	3000303	115.5

Эх сурвалж: 2015- 2019 оны жилийн эцсийн мал тооллогын дүн

Хүснэгт 6.4 Малыг төрлөөр, бодод шилжүүлснээр

	2015	2016	2017	2018	2019	2019/2018	
						Хувь	Зөрүү
Бодоор *	519869	584394	661517	668482	745557	111.5	77075
Толгойн тоо	2055765	2313963	2654388	2598440	3000303	115.5	401863
Тэмээ	118584	130493	141232	152281	157863	103.7	5582
Адуу	74170	85298	98651	96544	109526	113.4	12982
Үхэр	18653	22149	26997	26864	31653	117.8	4789
Хонь	447008	520905	613980	631412	718216	113.7	86804
Ямаа	1397350	1555118	1773528	1691339	1983045	117.2	291706

Бодод шилжүүлэхдээ адуу, үхрийг 1 бод, тэмээг 1.5 бод, 6 хонь 8 ямааг тус бүр 1 бод гэж тооцов.

ГАЗАР ТАРИАЛАН

Газар тариалангийн салбарт 2019 онд нийт 243.4 га талбайд тариалалт хийсний 59.1 га талбайд төмс, 120.2 га талбайд хүнсний ногоо, 64.0 га талбайд тэжээлийн ургамал тариалснаас 451.9 тн төмс, 881.8 тн хүнсний ногоо, 581.6 тн тэжээлийн ургамал хураажээ.

ХҮСНЭГТ 6.4 ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ТАРИАЛСАН ТАЛБАЙ, оноор / га /

	2010	2012	2013	2018	2019
Нийт тариалсан талбай	155.6	177.1	144.7	253.1	243.4
Төмс	83.2	65.8	64.5	71.1	59.1
Хүнсний ногоо	44.9	48.2	45.5	145.9	120.2
Тэжээлийн ургамал	27.5	63.1	34.7	36.1	64.0

Үүнээс:

Эх сурвалж: Албан ёсны статистикийн мэдээ

2019 оны жилийн эцсийн байдлаар аймгийн хэмжээнд нийт 7242.8 тн өвс, 1191.7 тн гар тэжээл бэлтгэн нөөцөлсөн байна.


ХҮСНЭГТ 6.5 ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ӨӨРИЙН ХҮЧЭЭР БЭЛТГЭСЭН ХАДЛАН НЭР, ТӨРЛӨӨР, тонн

	2015	2016	2017	2018	2019	2019/2018
Хадлан өвс	5360	6844.2	5626.6	7625.9	7242.85	95
Таримал тэжээл	247.5	57.2	17.7	8.11	17.6	217
Даршны ургамал	13.2	827.5	49.1	32.1	29.8	92.8
Гар тэжээл	1838.5	2598.3	1009.9	983.7	1191.73	121.1
Хужир шүү	4734.1	6189.6	3888.8	3931.6	2212.95	56.3
Төмс ногооны хаягдал	20.5	16.9	38.9	17.1	12.6	73.7
Үр тарианы хаягдал	17	0	25.8	3.4	4	117.6
Сүрэл	10.5	10.1	14.1	2	2	100

Эх сурвалж: Албан ёсны статистикийн мэдээ

ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРУУД

Бүлэг 7



7.1. АЖ ҮЙЛДВЭР

2019 онд аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн 3655.9 тэрбум төгрөг болж өнгөрсөн оны мөн үеэс 54.8 хувиар буюу 1294.8 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний эзлэх хувиар нь авч үзвэл: уул, уурхай, олборлох аж үйлдвэрийн борлуулалт 99.5 хувийг эзэлж байна. /Хүснэгт-7.1.1/

ХҮСНЭГТ 7.1.1 АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ, 2015-2019 он, үнийн дүнгээр


Бүтээгдэхүүний нэрс	Үнийн дүнгээр (мян.төг)					2019 2018
	2015	2016	2017	2018	2019	
Чулуун нүүрс	361337455	705142136.1	1264798536	2356963660	3637847297	154.3
Алт	0	253346.5	0	0	0	
Дулааны эрчим хүч	2463245.9	2470555.00	2524017.5	3710571.0	4057337.4	109.3
Боловсруулах аж үйлдвэр	183019	70863.8	0	461924.6	14031128.6	3037.5
Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	119677.8	72313.7	96220.1	120155	94225.5	78.4
Хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	116828.2	235139.5	13339.5	5292.3	9610.00	181.6
Ундаа үйлдвэрлэл	324750.8	299512.7	227176.3	336477.3	3381814.8	1005.1
Ус ариутгал, усан хангамж	548483.2	613450.1	624383.5	945772.5	1119900.1	118.4
Бүгд	436555543	366761382.6	1268283672	2361136155.6	3655935762.7	154.8

Эх сурвалж: Албан ёсны статистикийн мэдээ

Өмнөговь аймгийн хэмжээнд аж үйлдвэрийн салбарын борлуулалт сүүлийн 5 жилд тогтмол өсөлттэй байна. /ЗУРАГ 5 /

2019 оны эцэст 3605.4 тэрбум төгрөгийн борлуулалт хийгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 899.4 тэрбум төгрөгөөр буюу 33.2 хувиар өссөн байна. Аж үйлдвэрийн борлуулалтыг салбараар авч үзвэл уул уурхай, олборлох аж үйлдвэр 3586.2 тэрбум төгрөг, хүнсний боловсруулах аж үйлдвэр 15.1 тэрбум төгрөг, цахилгаан эрчим хүч үйлдвэрлэлийн борлуулалт 4.1 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн байна.

ХҮСНЭГТ 7.1.2 АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН БОРЛУУЛАЛТ, тэрбум төгрөг 2015-2019 оноор



7.2 БАРИЛГА



Барилга угсралт их засвар гэж барилга байшин барих болон инженерийн зориулалтаар зам гүүр, далан угсрах зэрэг инженерийн бусад байгууламжийг барих хэлбэрээр үндсэн хөрөнгийг бий болгох, шинэчлэх, засварлах, өргөтгөхөд чиглэгдсэн үйл ажиллагааг ойлгоно.


ХҮСНЭГТ 7.2.1 БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ сая.төг

	2016	2017	2018	2019
Улсын дүн	2928735.2	2926822.1	4009817.5	4747504.2
Төвийн бүс	443219.8	821381.4	1417255.0	1738541.2
Говьсүмбэр	10689.8	3802.1	3423.1	14551.8
Дархан-уул	79659.2	38812.8	91114.5	109825.6
Дорноговь	17046.2	95213	423281.8	170117.4
Дундговь	11230.2	8003.1	9515.0	146164.5
Өмнөговь	295485.2	562661.7	732711.8	1135373.4
Сэлэнгэ	9146.0	83716.1	13216.6	41790.3
Төв	19963.1	29172.6	143992.2	120718.2

Эх сурвалж: Албан ёсны статистикийн мэдээ

Барилга угсралт, их засварын ажилд Өмнөговь аймаг 2019 онд 1135.3 тэрбум төгрөгийн гүйцэтгэл хийсэн нь 2018 оноос 54.0 хувиар өсч, төвийн бүсийн дүнд 65.3 хувь, улсын дүнд 23.9 хувийг эзэлж байна.

ЗУРАГ 7.2.1 БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ сая.төг



7.3.ТЭЭВЭР, ХОЛБООНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО, РАДИО ЦЭГИЙН ТОО ТЭЭВЭР ҮЙЛЧИЛГЭЭ



Тээврийн салбарын статистик үндсэн үзүүлэлтүүдэд ачаа эргэлт, тээсэн ачаа, зорчигч эргэлт, авто машины тоо, шилжүүлсэн тонн.км, ажиллагсдын тоо орлого зэрэг орно.

Авто тээврийн статистик мэдээ тайланг аж ахуйн нэгжүүдээс аймгийн статистикийн хэлтэс цуглуулан авч нэгтгэн Улсын бүртгэл статистикийн

ерөнхий газарт дамжуулдаг.

Тээсэн ачаа эргэлт: Нийт тээвэрлэсэн ачааны хэмжээг зөөвөрлөсөн зайгаар үржүүлсэн үзүүлэлт

Зорчигч тээвэр эргэлт: Нийт зорчигчдын тоог тээвэрлэсэн зайгаар үржүүлсэн хэмжээ

2018 онд 14.5 мян.тн ачаа тээвэрлэж, 4355.3 мян.тн.км-ийн ачаа эргэлт хийсэн нь өнгөрсөн оноос тээсэн ачаа 423 мян.тн-оор буурч, ачаа эргэлт 15 дахин буурсан гүйцэтгэлтэй байна. Тээвэр бүхий байгууллагууд 2859.7 мян.хүн тээвэрлэж, 90036.4 мян.хүн.км-ийн зорчигч эргэлт хийсэн нь өнгөрсөн оноос Зорчигч тээвэрлэлт 117.5 хувиар буюу 1544.9 мян.хүнээр өсч, зорчигч эргэлт 47.7 хувиар буюу 82225.2 мян.хүн.км-ээр буурсан гүйцэтгэлтэй байна. Тээврийн орлого 8595.1 сая төгрөг болж өнгөрсөн оноос 32.5 хувиар буюу 4130.7 сая төгрөгөөр буурсан байна.

ХҮСНЭГТ 7.3.1 ТЭЭВРИЙН САЛБАРЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2017	2018	2019	2019/2018
Ачаа эргэлт	мян.тн.км	65206.6	4355.3	6183.8	142.0
Тээсэн ачаа	мян.тн	437.5	14.5	23.8	164.0
Зорчигч эргэлт	мян.хүн.км	172262	90036.4	188054	200.0
Үүнээс: дотоодод	мян.хүн.км	172262	90036.4	188054	200.0
Тээсэн зорчигч	мян.хүн	1314.8	2859.7	3202	111.9
Үүнээс: дотоодод	мян.хүн	1314.8	2859.7	3202	111.9
Тээврийн орлого	сая.төг	12725.8	8595.1	13053.5	151.8
Тээврийн ажиллагсад	хүн	466	386	428	110.8

Эх сурвалж: Албан ёсны статистикийн мэдээ

ХҮСНЭГТ 7.3.2 АВТО ТЕХНИКИЙН УЛСЫН ҮЗЛЭГ

Үүнээ:


Аймаг нийслэл	2017	2018	2019	Төрлөөр				Ашигласан хугацаагаар		
				суудлын	ачааны	автобус	тусгай зориулалты	3 жил хүртэл	4-9 жил	10-аас дээш
Бүгд	536399	585363	614753	426065	131573	18570	9155	13408	126462	474883
Төвийн бүс	60 425	67905	89458	54254	32038	1166	2000	1617	14401	73440
Говьсүмбэр	2 333	2311	2338	1639	607	38	54	29	402	1907
Дархан-Уул	9 152	8941	15784	12190	3270	176	148	107	2525	13152
Дорноговь	11 155	11909	12567	8535	3590	183	259	183	2110	10274
Дундговь	2 954	2818	7821	4566	3043	125	87	78	997	6746
Өмнөговь	16 487	22700	22328	10865	9860	352	1251	1014	5523	15791
Сэлэнгэ	10 403	11219	16044	9921	5857	156	110	91	1794	14159
Төв	7 941	8007	12576	6538	5811	136	91	115	1050	11411

Эх үүсвэр: Авто тээврийн үндэсний төв ТӨҮГ-ын мэдээлэл

Улсын хэмжээний нийт 614.7 мянган авто машины 3.6 хувийг манай аймагт бүртгэлтэй тээврийн хэрэгсэл эзэлж байна. Манай аймгийн хэмжээнд 2019 онд авто техникийн улсын үзлэгээр бүх төрлийн авто машин 22328 болж өнгөрсөн оноос 1.7 хувиар буюу 372 тээврийн хэрэгслээр буурсан байна.

ЗУРАГ 7.3.3 АВТО МАШИНЫ УЛСЫН ҮЗЛЭГИЙН ДҮН 2018 он /бүтцээр/

Авто машиныг төрлөөр нь авч үзвэл: 42 хувь буюу 10.8 мянга нь суудлын авто машин, 39 хувь буюу 9.8 мянга нь ачааны, 14.0 хувь буюу 3526 автобус 5.0 хувь буюу 1.2 тусгай зориулалтын авто машин байна.



7.4 ХОЛБООНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО, РАДИО ЦЭГИЙН ТОО

Холбооны нийт орлого, үүнээс хүн амаас орсон орлого телефон болон радио цэгийн тоо зэрэг үндсэн үзүүлэлтийг харуулав.

Нийт орлого Холбооны үйл ажиллагааны нийт орлого гэдэгт цахилгаан холбоо, хөдөлгөөнт холбоо, мэдээллийн технологи, шуудангийн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагуудын тайлант хугацааны нийт орлогыг оруулна.

Үүрэн телефон хэрэглэгч Тухайн байгуулсан сүлжээний хүрээнд хөдөлгөөнтэй /нэгээс нөгөө үүрт шилжих/ ашиглах боломжтой утасгүй холбооны хэрэглэгч юм.


ХҮСНЭГТ 7.4.1 ХОЛБООНЫ САЛБАРЫН ҮЗҮҮЛЭЛТ

	Хэмжих нэгж	2016	2017	2018	2019	2019/2018
Нийт орлого	сая.төг	411.2	422.4	403.3	631	156.4
Хүн амаас олох орлого	сая.төг	165.8	64.5	47.3	94.7	200
Телефон цэг	ш	1188	950	912	902	98.9

Эх сурвалж: Захиргааны статистикийн мэдээ


2019 онд холбооны нийт орлого 631 сая.төг болсон нь өнгөрсөн оны мөн үеэс 56.4 хувиар буюу 227.7 сая төгрөгөөр өссөн байна. Хүн амаас олох орлого нь 94.7 сая.төг болж өнгөрсөн оноос 1 дахин буюу 47.4 сая.төгрөгөөр өссөн байна. Нийт орлогын 15.0 хувийг хүн амаас орох орлого эзэлж байна.

ЗУРАГ 7.4.1 ХОЛБООНЫ САЛБАРЫН НИЙТ ОРЛОГО, оноор, сая.төг



АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО,
БҮТЭЦ

Бүлэг 8



Монгол улсад нийт бүртгэлтэй 187046 аж ахуйн нэгж, байгууллага байгаагийн 1.6 хувь, төвийн бүсийн 17.8 хувийг Өмнөговь аймгийн аж ахуйн нэгж, байгууллага эзэлж байна.

ХҮСНЭГТ 8.1. БИЗНЕС РЕГИСТРИЙН САНД БҮРТГЭЛТЭЙ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА
бүс, аймаг, нийслэлээр 2015-2019 он

Аймаг, нийслэл	2015	2016	2017	2018	2019
Улсын дүн	126560	141502	155065	174936	187046
Төвийн бүс	11700	12587	13804	15516	16304
Говьсүмбэр	351	398	439	469	492
Дархан-Уул	3196	3480	3768	4000	4154
Дорноговь	1181	1298	1439	1640	1751
Дундговь	861	907	965	1071	1118
Өмнөговь	1797	1966	2256	2731	2906
Сэлэнгэ	2528	2619	2894	3411	3543
Төв	1786	1919	2043	2194	2340

Эх сурвалж: Албан ёсны статистикийн мэдээ

2019 онд бизнес регистрийн санд бүртгэлтэй 2906 аж ахуйн нэгж, байгууллагын 65.6 хувийг буюу 1754 үйл ажиллагаа явуулж байна. Бүртгэлтэй аж ахуй нэгж байгууллагын тоо 2015 оноос 645 буюу 58.1 хувь, өнгөрсөн оноос 81 буюу 4.8 хувиар тус тус өссөн байна.

ХҮСНЭГТ 8.2.ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА
бүс, аймаг, нийслэлээр 2015-2019 он

Аймаг, нийслэл	2015	2016	2017	2018	2019
Улсын дүн	64301	72182	78585	87725	93820
Төвийн бүс	7862	8499	9050	9724	10108
Говьсүмбэр	278	313	302	374	384
Дархан-Уул	1811	1973	2130	2198	2254
Дорноговь	922	1002	1069	1192	1261
Дундговь	585	601	639	671	705
Өмнөговь	1109	1281	1429	1673	1754
Сэлэнгэ	2032	2108	2214	2300	2372
Төв	1125	1221	1267	1316	1378

Эх сурвалж: Албан ёсны статистикийн мэдээ

Өмнөговь аймгийн хэмжээнд 2019 оны 4 дүгээр улирлын байдлаар 1754 аж ахуй, нэгж байгууллага үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд үүний 49.9 хувийг Даланзадгад суманд үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгж байгууллага эзэлж байна. Харин үйл ажиллагаа явуулж буй нийт аж ахуй нэгж байгууллагын 1.2 хувийг Хүрмэн суманд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгжүүд эзэлж байна./ЗУРАГ-2 /

ХҮСНЭГТ 8.3 ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА сумдаар, 2015-2019 оны IV улиралаар

Үзүүлэлт	2015-IV	2016-IV	2017-IV	2018-IV	2019-IV
Өмнөговь	1,109	1,281	1,429	1,629	1,754
Баяндалай	27	26	26	29	29
Баян-Овоо	27	32	36	41	44
Булган	35	35	37	37	40
Гурвантэс	55	58	64	75	83
Мандал-Овоо	22	22	25	38	36
Манлай	30	31	32	39	41
Номгон	25	28	30	29	31
Ноён	24	25	27	25	26
Сэврэй	21	23	24	29	31
Ханбогд	142	175	195	230	259
Ханхонгор	26	28	29	26	30
Хүрмэн	19	20	21	21	21
Цогт-Овоо	21	24	29	32	32
Цогтцэций	108	125	132	153	176
Даланзадгад	527	629	722	825	875

Эх сурвалж: Албан ёсны статистикийн мэдээ

Дүгнэлт

Өмнөговь аймаг 2019 оны эцэст 69902 хүн амтай болж 2018 оны эцсийн хүн амын мэдээнээс 2.6 хувиар буюу 1788 хүнээр өслөө. Нийт хүн амын 51.1 хувь буюу 35720 эрэгтэйчүүд, 48.9 хувь буюу 34182 эмэгтэйчүүд эзлэж байна. Насны бүтцээр ангилвал 31.8 хувийг 0-14 насны хүүхэд, 62.0 хувийг 15-59 насны, 6.2 хувийг 60-с дээш насны хүн ам эзэлж байна.

Эдийн засгийн идэвхитэй хүн амд нийт ажиллагч болон бүртгэлтэй ажилгүйчүүдийг хамруулж ойлгож болно. Тус аймгийн хөдөлмөрийн насны хүн ам 43359 байгаагийн 30517 буюу 70.3 хувийг ажиллагчид эзэлж байна. Хөдөлмөрийн насны хүн амын тоог өмнөх онтой харьцуулахад 653 хүнээр буюу 1.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Төвийн бүсийн эдийн засгийн идэвхитэй хүн ам 2019 онд 218.0 мянган хүн байгаа нь 2018 оныхоос 16.1 мянган хүнээр буюу 6.8 хувиар буурсан байна. Өмнөговь аймгийн хувьд эдийн засгийн идэвхтэй 32.5 мянга хүн ам байгаа нь өмнөх онтой харьцуулахад 0.5 мянган хүнээр буюу 1.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Өмнөговь аймгийн хувьд 2019 оны ажиллагчдын тоо 30.5 мянгад хүрсэн нь 2018 оныхоос 3.0 хувиар буюу 0.9 мянган хүнээр өссөн нь уул уурхайн салбарын үйл ажиллагаа тогтмолжиж, ажлын байр нэмэгдсэнтэй холбоотойгоор холбон тайлбарлаж болох юм. Нийт ажиллагчдын 52.2 хувь нь эрэгтэйчүүд байна.

Урьдчилсан гүйцэтгэлээр 2019 онд Өмнөговь аймаг Монгол улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 2.3 хувь, төвийн бүсийн 20.5 хувь болох 728.5 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаагийн дээр нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн 10.5 сая төгрөг болж улсын хэмжээнд Орхон аймаг, Улаанбаатар хот, Дорнод аймгийн дараа 4-т эрэмбэлэгдэж байна. Дотоодын нийт бүтээгдэхүүнийг салбараар авч үзвэл хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуйн салбар 19.8 хувь, аж үйлдвэр, барилгын салбар нь 48.1 хувь, үйлчилгээний салбар 32.1 хувийг тус тус эзэлж байна.

Аймгийн хэмжээгээр эрүүл мэндийн байгууллага 101 ажиллаж байгаагаас улсын төсвийн эмнэлэг 24, өрхийн эмнэлэг 4, цэргийн ангийн 3 эмнэлэг, хувийн эмнэлэг 25, хувийн эмийн сан 43, эргэлтийн эмийн сан 14, эм ханган нийлүүлэх төв 4 тус тус ажиллаж байна.

Мөнгөн хадгаламжийн үлдэгдэл 2019 онд 173.2 тэрбум төгрөгт хүрсэн байна. Сүүлийн 5 жилийн эцсийн байдлаар үзэхэд иргэдийн мөнгөн хадгаламж тогтмол өссөн бөгөөд 2019 оныг өмнөх онуудтай харьцуулбал 2018 оноос 13.8 хувиар, 2017 оноос 41.9 хувиар, 2016 оноос 88.5 хувиар, 2015 оноос 2.0 дахин тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Барилга угсралт, их засварын ажилд Өмнөговь аймаг 2019 онд 1135.3 тэрбум төгрөгийн гүйцэтгэл хийсэн нь 2018 оноос 54.0 хувиар өсч, төвийн бүсийн дүнд 65.3 хувь, улсын дүнд 23.9 хувийг эзэлж байна.

2019 оны жилийн эцсийн мал тооллогоор аймгийн хэмжээгээр 7707 малтай өрх, үүнээс 6108 малчин өрх мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлж байна. Аймгийн хэмжээний нийт өрхийн 36.5 хувийг малтай өрх эзэлж байна.

2019 онд мал аж ахуйн салбарт 9671 малчид ажиллаж байна. Нийт малчдын 43.8 хувь нь буюу 4237 эмэгтэйчүүд байна.

Малчин өрхийн тоо өмнөх оныхоос 2.6 хувиар буюу 157 өрхөөр, малчдын тоо өмнөх оноос 0.8 хувиар буюу 78 малчнаар өссөн үзүүлэлт харагдаж байна.

2019 оны мал тооллогын дүнгээр нийт малчин өрхийн 83.7 хувь буюу 5115 өрх цахилгааны эх үүсвэртэй, 77.8 хувь буюу 4754 өрх телевизортой, 57.6 хувь буюу 3521 өрх автомашинтай, 56.4 хувь буюу 3442 өрх мотоциклтой, 0.5 хувь буюу 28 өрх трактортой байна.

2019 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр Өмнөговь аймгийн 15 сумын 59 багт 3.0 сая толгой мал тоолуулж 2018 оныхоос 401.8 мянган толгой малаар буюу 15.5 хувиар өссөн байна.

Тооллогын дүнгээр тэмээний тоо 157863 толгой, адуу 109526 толгой, үхэр 31653 толгой, хонь 718216 толгойд, ямаа 1983045 толгойд хүрсэн байна. Өмнөх оныхоос тэмээ 5582 толгойгоор буюу 3.7 хувиар, хонь 86804 толгойгоор 13.7 хувиар, адуу 12982 толгойгоор 13.4 хувиар, үхэр 4789 толгойгоор буюу 17.8 хувиар, ямаа 291706 толгойгоор буюу 17.2 хувиар тус тус өссөн байна.

АЙМГИЙН ДУУ

ТЭМЭЭН СҮРТИЙН ТОВЬ

Шүлэг Н.Цэдэв

Ая У.Батдэлгэр

Тэртээ Алтай уулсын
Үзүүр Турван сайхан
Тэмээн сүргийн говьдоо
Тэнгэр шүргэм бараатай
Ингэн тэмээний нүд шиг
Булаг шанд нь бүлээн
Элсэн хонгор говьдоо
Эхийн сүү шиг мэлтэрнэ
Мандах жаргах бүрийдээ
Зэсэн улаан наран
Манхан шаргал говьдоо
Илчээ шингээн уусна
Ингэн тэмээний нүд шиг
Булаг шанд нь бүлээн
Элсэн хонгор говьдоо
Эхийн сүү шиг мэлтэрнэ
Байцын оройд сэргийлдэх
Аргаль янгирыг хараад
Уран зэрэглээт говьдоо
Уярсан сэтгэл хоргодно
Ингэн тэмээний нүд шиг
Булаг шанд нь бүлээн
Элсэн хонгор говьдоо
Эхийн сүү шиг мэлтэрнэ

